



## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 01 сарын 31 өдөр

Дугаар А/60

Арвайхээр

### Зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6.а, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 дэх заалт тус тус үндэслэн, Засгийн газрын 2016 оны 233 дугаар тогтоолоор батлагдсан “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Зөвлөлийн дарга: Аймгийн Засаг даргын орлогч (хууль зүйн, салбар хариуцсан)


Гишүүдэд: - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга  
- Аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газрын дарга  
- Аймгийн Засаг даргын дэргэдэх Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дарга  
- Аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн газрын Нийгмийн хэв журмыг хамгаалах тасгийн дарга  
- Аймгийн мэдээлэл шуурхай удирдлагын төвийн дарга  
- Аймгийн Худалдаа аж үйлдвэрийн танхимын дарга (зөвшилцсөнөөр)  
- Аймгийн Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн дарга  
- Аймгийн Ажил олгогчдий холбооны тэргүүн (зөвшилцсөнөөр)  
- ШӨХТГазрын Өвөрхангай аймаг дахь улсын байцаагч

Нарийн бичгийн дарга: - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн

2. Нутаг дэвсгэрийн хэмжээнд Зөвлөлийн үйл ажиллагааг удирдлага зохион байгуулалтаар хангаж, Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулж, тайлан, мэдээг танилцуулж ажиллахыг Зөвлөлийн дарга (И.Доржсүрэн)-д даалгасугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын тухай 2016 оны А/496 “Орон тооны бус зөвлөл шинэчлэн байгуулах тухай, 2017 оны А/262 “Орон тооны бус зөвлөл салбар зөвлөл байгуулах тухай” захирамжийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100142